



## НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 09 сарын 07 өдөр

Дугаар А/93

Улаанбаатар хот

### Г Буудлага явуулах тухай Г

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2019 оны 17 дугаар зарлигийн нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Цэргийн дотоод албаны дүрэм"-ийн 322, 323, 324, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын 2006 оны "Буудлагын дасгалын курст нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" 31 дүгээр тушаал, Батлан хамгаалахын сайдын 2017 оны А/178 дугаар тушаалаар батлагдсан "Үндэсний батлан хамгаалах их сургуулийн дүрэм"-ийн 11.7.1, 18.2.12, Үндэсний батлан хамгаалах их сургуулийн захирлын 2017 оны А/55 дугаар тушаалаар батлагдсан "Хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн аюулгүй ажиллагааны нэгдсэн заавар", нийслэлийн Онцгой байдлын газрын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2.1.24-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нийслэлийн Онцгой байдлын газрын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, сургалтын хөтөлбөрийн дагуу Гал түймэр унтраах аврах ангийн шуурхай удирдлагын операторуудын нэгдсэн сургалтад хамрагдах нийт 60 ахлагч бүрэлдэхүүнээр сургуулийн буудлагын автоматын анхны дасгалыг 1 удаа 2019 оны 09 дүгээр сарын 08-ны өдөр Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн "Шар хад"-ны хээрийн сургалтын төвийн буудлагын талбайд явуулсугай.

1. Сургуулийн буудлага удирдах албан тушаалтнуудыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Үүнд:

Буудлагын ахлах удирдагч:

Д.Ганхөлөг

Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн  
Ерөнхий цэргийн тэнхимийн Галын бэлтгэлийн  
багш, ахмад,

Буудлагын хэсгийн удирдагч:

Ш.Буяндэлгэр

Нийслэлийн Онцгой байдлын газрын  
Гамшгийн шуурхай удирдлагын хэлтсийн  
мэргэжилтэн, хурандаа,

Ч.Төгсбаяр	Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн Хээрийн сургалтын төвийн дарга, ахмад,
Талбайн хянагч:	
Х. Хадхүү	Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн Зэвсгийн албаны дарга, дэд хурандаа,
Галт хэрэглэл түгээгч:	
З.Мөнх-Од	Нийслэлийн Онцгой байдлын газрын Гамшгийн шуурхай удирдлагын хэлтсийн мэргэжилтэн, ахмад,
Буудлагын эмч:	
Б.Анар	Нийслэлийн Онцгой байдлын газрын Гамшгийн шуурхай удирдлагын хэлтсийн Нийгмийн эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн, дэслэгч,
Буудлагын харуул:	
Б.Халиунцэцэг	Нийслэлийн Онцгой байдлын газрын Гал түймэртэй тэмцэх хэлтсийн Шуурхай зохицуулалтын оператор, ахлах ахлагч,
О.Шинэтунгалаг	Нийслэлийн Онцгой байдлын газрын Гал түймэртэй тэмцэх хэлтсийн Шуурхай зохицуулалтын оператор, ахлах ахлагч

2. Буудлага явуулахад шаардагдах 7.62 мм-ийн АК буу 10 иж бүрдлийг Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн Ар талын хэлтсээс түр хугацаанд хангуулсугай.

3. Буудлагад оролцох бүрэлдэхүүнд буудлагын үеийн аюулгүй арга хэмжээний зааврыг сайтар судлуулж, хүн нэг бүрээр гарын үсэг зуруулж дадлагажуулан, галт хэрэглэлийн зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг буудлагын ахлах удирдагч, ахмад Д.Ганхөлөгт үүрэг болгосугай.

ДАРГА,  
ХУРАНДАА  Ж.НҮЛТЭМСҮРЭН

